

“СОЛОМОН ИНВЕСТМЕНТС ББСБ”  
ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2026 оны 03 сарын 09 өдрийн 26/11 тоот  
тогтоолын Хавсралт №.1.



SOLOMON INVESTMENTS

## ДОТООД ХЯНАЛТЫН ЖУРАМ

---

Баримт бичгийн төрөл/ Type:

Дотоод хяналтын журам

---

Хамрах хүрээ/ Area:

“СОЛОМОН ИНВЕСТМЕНТС ББСБ”

ХХК-ийн ажилтнуудад

Нууцын зэрэглэл/ Confidentiality:

Дотоодод нээлттэй

Баримт бичгийн дугаар/Number:

... 26 / 11 ...

Боловсруулсан/ Prepared by:

Хуулийн хэлтэс

Баталсан/ Approved by:

“СОЛОМОН ИНВЕСТМЕНТС ББСБ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл

Хуудасны тоо/ Page number:

09 хуудас

Хянан нийцүүлэх давтамж:

Жилд 1 удаа

Батлагдсан огноо/ Effective date:

2026. оны 03 сарын 09

---

## АГУУЛГА

Гарчиг	
Нэг. Нийтлэг үндэслэл .....	3
Хоёр. Зорилго.....	3
Гурав. Нэр томъёоны тайлбар .....	3
Дөрөв. Үндсэн чиглэл .....	4
Тав. Дотоод хяналтыг хэрэгжүүлэх этгээд .....	4
Зургаа. Хяналтын үйл ажиллагааны процесс .....	7
Долоо. Хяналтын шалгалтын дараах процесс .....	8
Найм. Дотоод хяналтын үйл ажиллагаанд хориглох зүйлс.....	8
Ес. Бусад.....	9

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү Дотоод хяналтын журам (цаашид “журам” гэх)-ын зорилго нь Соломон Инветмент ББСБ ХХК (цаашид “ББСБ” гэх)-ийн дотоод хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, дотоод хяналтын нэгжийн эсхүл ажилтны ажиллах зарчим, аудит хийх чиглэл, хэрэгжүүлэх арга, хэлбэрийг тодорхойлоход оршино.
- 1.2. ББСБ нь дотоод хяналтын үйл ажиллагаандаа Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид “Хороо” гэх)-ны тогтоол, журам, олон улсад болон Монгол улсад хүлээн зөвшөөрөгдсөн Компанийн засаглалын кодекс, бусад хууль тогтоомж, болон холбогдох бусад дүрэм, журмыг удирдлага болгон хэрэгжүүлнэ.

### Хоёр. Зорилго

- 2.1. Үйл ажиллагааны дотоод хяналт нь ББСБ-ын үйл ажиллагааг үнэлэх, сайжруулах, түүний үнэ цэнийг нэмэгдүүлэхээр хараат бус, бие даасан, бодитойгоор баталгаа өгөх ба зөвлөх үйл ажиллагаа байна.
- 2.2. ББСБ нь дотоод хяналтын бодлогоо тодорхойлохдоо үйл ажиллагаандаа зайлшгүй анхаарах асуудлыг тусган, ББСБ-ын онцлог, тухайн үеийн нөхцөл байдал, хэтийн төлөвт тулгуурлана.
- 2.3. Дотоод хяналт шалгалт нь хууль дээдлэх, хараат бус ил тод, шударга, бодитой, хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид байх зарчимд тулгуурлана.
- 2.4. Дотоод хяналт шалгалтын зорилго нь Компанийн үйл ажиллагаанд хяналт тавьж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэхэд чиглэнэ.
- 2.5. Дотоод хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, Компанийн үйл ажиллагааг бүрэн хамарч байвал зохино.

### Гурав. Нэр томъёоны тайлбар

- 3.1. Энэхүү журамд тодорхойлсон дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

<b>Мэдээлэл</b>	ББСБ-ын болон түүний харилцагчийн үнэ цэнэтэй өгөгдлийг
<b>Дотоод хяналт</b>	Хяналтын нотолгоог олж авах, тэдгээрийг бодитойгоор үнэлж, хяналтын шалгуурыг хангаж багаа эсэхийг нотлох системтэй, бие даасан, баримтажсан процессыг
<b>Хяналтын нотолгоо</b>	Хяналтын шалгуурт хамааралтай, батлах боломжтой баримт болон бусад мэдээлэл. <b>Анхаарах:</b> Хяналтын нотолгоо нь тоон болон чанарын байж болно.

**Хяналтын шалгуур**

Хууль, бодлого, журам, стандарт болон дагаж мөрдвөл зохих баримт бичгийн хүрээнд тавигдсан шаардлагын нэгдэл.

**Анхаарах:** Хяналтын шалгуурыг хяналтын нотолгоотой харьцуулахад ашиглана.

**Аудитор**

Аудит хийх чадамжтай этгээд

**Дөрөв. Үндсэн чиглэл**

- 4.1. ББСБ нь дотоод хяналтыг тусгай нэгж байгуулах эсхүл ажилтан томилох эсхүл тусгай зөвшөөрөл бүхий хөндлөнгийн этгээдээр гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж болно.
- 4.2. Дотоод хяналт шалгалтын нэгж эсхүл ажилтан нь хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд захирагдах бөгөөд зохион байгуулалтын хувьд Гүйцэтгэх захирлаас хараат бус байна.
- 4.3. Дотоод хяналтыг хэрэгжүүлэх этгээд нь ББСБ-ын бүхий л үйл ажиллагааны түвшинд эрсдэлд суурилсан дотоод хяналтын үйл ажиллагааг явуулах бөгөөд дараах чиглэлтэй байна:
  - 4.3.1. ББСБ-ын засаглалын үйл явцыг үнэлж, сайжруулах зөвлөмж өгөх;
  - 4.3.2. эрсдэлийн удирдлагын үйл явцын үр нөлөөтэй ба үр ашигтай байдлыг үнэлэх, сайжруулах;
  - 4.3.3. дотоод хяналтын системийн үр нөлөөтэй ба үр ашигтай байдалд үнэлгээ хийх, тэдгээрийн байнгын сайжруулалтад дэмжлэг үзүүлэх, баталгаа гаргах;
  - 4.3.4. ББСБ-ын санхүүгийн үйл ажиллагаа нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн, мөрдөж буй заавар, журмын дагуу үнэн зөв тайлагнаж буй эсэхэд баталгаажуулалт өгөх.

**Тав. Дотоод хяналтыг хэрэгжүүлэх этгээд**

- 5.1. Дотоод хяналтыг хэрэгжүүлэх этгээд нь дараах зарчмуудыг баримталж ажиллана. Үүнд:
  - 5.1.1. шударга байх;
  - 5.1.2. мэргэжлийн мэдлэг, ур чадвартай байх;
  - 5.1.3. хараат бус, бие даасан байх;
  - 5.1.4. ББСБ-ыг стратеги зорилго, зорилтдоо амжилттай хүрэхэд дэмжлэг үзүүлж, учирч болох эрсдэлийг тодорхойлох;
  - 5.1.5. хүний нөөц, төсөв санхүүг оновчтой төлөвлөх;
  - 5.1.6. хяналтын үйл ажиллагааг тасралтгүй сайжруулж байх;
  - 5.1.7. аудитад хамрагдаж буй газар, нэгжүүдтэй үр дүнтэй харилцах;

- 5.1.8. хяналтын эцсийн дүгнэлтэд эрсдэлд суурилсан баталгаажуулалт өгөх;
- 5.1.9. байгууллагын үйл ажиллагааг сайжруулахаар хийж буй өөрчлөлт, шинэчлэлийг дэмжих.
- 5.2. Дотоод хяналт шалгалтын нэгж эсхүл ажилтан дараах нийтлэг эрх, үүрэгтэй байна.  
Үүнд:
- 5.2.1. Зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт, шалгалтыг гүйцэтгэж дүнг тайлагнах;
- 5.2.2. Хяналт шалгалт явуулахдаа удирдлагатай шууд харилцаж тэдгээрээс шаардлагатай мэдээ, судалгаа гаргуулах, холбогдох ажилтны ажлыг шалгаж танилцах, илэрсэн зөрчил дутагдлын талаар тайлан гаргуулах;
- 5.2.3. Илэрсэн зөрчил дутагдлын шалтгаан нөхцөлийг тодруулан зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах;
- 5.2.4. Шаардлагатай бол илэрсэн зөрчил дутагдлын шалтгаан нөхцөлийг арилгах асуудлаар болон зөрчил гаргасан этгээдэд хариуцлага ногдуулах талаар Гүйцэтгэх захиралд санал тавьж шийдвэрлүүлэх;
- 5.2.5. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар судалгаа, дүгнэлт гаргах;
- 5.2.6. Холбогдох дүрэм, журам, байгууллагын стандартыг боловсронгуй болгох талаар судалгаа, дүгнэлт гаргах;
- 5.2.7. Дотоод хяналт, шалгалтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхыг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил, арга зүйн зөвлөгөө авах, зөрчлийг нь арилгаж чадахгүй асуудлыг хууль хяналтын байгууллагын эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, хамтран ажиллах талаар санал боловсруулан удирдлагад танилцуулах;
- 5.2.8. Байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилт, болон зөрчлийн талаарх мэдээллээр удирдлагыг хангах;
- 5.2.9. Хийсэн хяналт шалгалтын талаар бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх;
- 5.2.10. Дотоод хяналт, шалгалтаар хүний амь нас, эрүүл мэнд, нийгэм болон хүрээлэн байгаа орчны аюулгүй байдалд шууд буюу шууд бусаар ноцтой аюул, хохирол учруулж болохуйц нөхцөлд байдал үүссэн нь тогтоогдвол түүнийг арилгах арга хэмжээг нэн даруй авч эрх бүхий байгууллагад мэдэгдэх.
- 5.3. ББСБ нь дотоод хяналтыг тусгай нэгж байгуулан хэрэгжүүлэх тохиолдолд ББСБ-ын дотоод хяналтын нэгжийн дарга, ажилтнуудыг Хяналтын хорооноос санал болгосноор Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ-гүй тохиолдолд Хувьцаа эзэмшигчийн хурлаас/ томилно.
- 5.4. ХЭХ/ТУЗ нь дотоод хяналтын үйл ажиллагааг дараах байдлаар хариуцаж ажиллана:
- 5.4.1. дотоод хяналтын бодлогыг тодорхойлох, батлах, түүнийг өөрчлөх;
- 5.4.2. эрсдэлд суурилсан дотоод хяналтын дунд хугацааны төлөвлөгөөг батлах, гүйцэтгэлийг хянах;
- 5.4.3. дотоод хяналтын нэгжийн орон тоо, төсөв, удирдлага, ажилтнуудын цалин, урамшууллыг тогтоох;

- 5.4.4. дотоод хяналтын нэгжийн ажиллах журам, дүрэм, гарын авлагыг батлах;
- 5.4.5. дотоод хяналтын үйл ажиллагаа нь ББСБ-ын үйл ажиллагаанд эергээр нөлөөлж, туслалцаа дэмжлэг үзүүлж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- 5.4.6. дотоод хяналтын тайлан, дүгнэлттэй тухай бүр танилцаж, аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу авах арга хэмжээнүүдийн талаар шийдвэр гаргах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих;
- 5.4.7. дотоод хяналтын тогтолцоо, үйл ажиллагааг Дотоод хяналтын мэргэжлийн практикийн олон улсын стандартаар тогтоосон хэлбэрээр зохион байгуулж, хэрэгжүүлж чадаагүйгээс ББСБ-д ноцтой эрсдэл учирсан болон учирч болзошгүй нөхцөл байдал үүссэн бол дотоод аудиторт хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авах.
- 5.5. Гүйцэтгэх удирдлага, ажилтнууд нь дотоод хяналтын нэгж эсхүл ажилтантай дараах байдлаар хамтран ажиллана:
- 5.5.1. дотоод хяналтын нэгж эсхүл ажилтныг хараат бусаар ажиллах нөхцөл боломжоор бүрэн хангаж, ажилд нь хүндрэл учруулахгүй байх;
- 5.5.2. дотоод хяналтын удирдамжид зааснаар дотоод аудиторын шаардсан мэдээ, материал, лавлагаа, тайлбарыг аудит хийлгэж байгаа нэгжийн удирдлага, ажилтнууд холбогдох дүрэм, зааврын дагуу хугацаанд нь гаргаж өгөх бөгөөд шаардлагатай тохиолдолд ярилцлага, санал асуулгад оролцох;
- 5.5.3. дотоод аудитаар гарсан зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллах.
- 5.6. Дотоод хяналтын нэгж эсхүл ажилтан нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:
- 5.6.1. дотоод хяналтын үйл ажиллагааны төлөвлөгөө, ажиллах дүрэм, журам, гарын авлагыг боловсруулж, ХЭХ/ТУЗ-өөр батлуулан, хэрэгжүүлэх;
- 5.6.2. хууль тогтоомж, бодлогын баримт, дүрэм, журам, дотоод хяналтын олон улсын стандартын дагуу дотоод хяналтыг гүйцэтгэх;
- 5.6.3. дотоод хяналтын тайланг гүйцэтгэх удирдлагад танилцуулж, баталгаажуулсны дараагаар Хяналтын хороогоор хэлэлцүүлэх;
- 5.6.4. эрсдэлд суурилсан дотоод хяналтыг гүйцэтгэж, ББСБ-ын өндөр эрсдэлтэй хэсгүүдэд ажиллах;
- 5.6.5. дотоод хяналтыг мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу явуулах ба ББСБ-ын нэгжийн ажилтнуудаас ярилцлага, асуулга, лавлагаа, тодруулга авч, ажлын баримтад тулгуурлан үнэн зөв, бодитой үнэлгээ, дүгнэлт гаргах;
- 5.6.6. дотоод хяналтын нэгжийн удирдлага эсхүл ажилтан нь дотоод хяналтыг тогтоосон хугацаанд чанартай, үр дүнтэй байхаар ажлын хэсгийг зохион байгуулахын зэрэгцээ ажлын явц, гүйцэтгэлийн талаар болон шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хяналтын удирдамжид өөрчлөлт оруулах саналаа ХЭХ/ТУЗ-д танилцуулж, шийдвэрлүүлэх;
- 5.6.7. дотоод хяналтыг хийхдээ шалгуулагчийн үйл ажиллагаанд хүндрэл учруулахгүйгээр явуулах.
- 5.7. Дотоод хяналт нь дараах үйл ажиллагааны бүх шатанд хэрэгжинэ. Үүнд:

- 5.7.1. Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа;
  - 5.7.2. дотоод хяналт;
  - 5.7.3. эрсдэлийн удирдлага;
  - 5.7.4. ББСБ-ын бусад нэгжийн удирдлагын үйл ажиллагаа;
  - 5.7.5. ББСБ-ын ажилтны үйл ажиллагаа.
- 5.8. Дотоод хяналт шалгалтыг дараах чиглэлээр зохион байгуулна. Үүнд:
- 5.8.1. Зээлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт;
  - 5.8.2. Компанийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтэд тавих хяналт шалгалт;
  - 5.8.3. Компанийн байгаль орчинд үзүүлэх нөлөөлөлд хийх хяналт шалгалт,
  - 5.8.4. Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд тавих хяналт шалгалт,
  - 5.8.5. Өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт.

#### Зургаа. Хяналтын үйл ажиллагааны процесс

- 6.1. Дотоод хяналтыг хэрэгжүүлэх этгээд нь хяналтын үйл ажиллагаа эхлэхийн өмнө нээлтийн хурал хийнэ.
- 6.2. Дотоод хяналтын шалгалтын нээлтийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:
  - 6.2.1. Аудиторууд болон тэдний чадамжийн талаар товч мэдээлэл /хэрэв гадны байгууллагынх бол/
  - 6.2.2. Хяналтын шалгуур, хамрах хүрээ, болон зорилго
  - 6.2.3. Хяналтын хугацаанд баримтлах аргачлал зэрэг хяналтын процессын талаар товч мэдээлэл
  - 6.2.4. Хяналтыг тайлагнах аргачлалын талаар товч мэдээлэл
  - 6.2.5. Аудитаар шалгуулагч/Нэгжийн зүгээс хяналтын дараа хүлээх үр дүн
  - 6.2.6. Хяналтын үед үүссэн асуудлыг мэдээлэх/ цааш дамжуулах
  - 6.2.7. Хяналтын төлөвлөгөөг баталгаажуулах, шаардлагатай бол аудитаар шалгуулагчаас авсан оролтод тулгуурлан төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах
- 6.3. Аудитор нь дотоод хяналтын шалгалтыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ. Дотоод хяналтын шалгалтыг баримт бичгийн хяналт, ажиглалт болон ярилцлагын аргуудыг хослуулан гүйцэтгэнэ.
- 6.4. Аудитор нь хяналтын шалгалтын хүрээнд илэрсэн бүх үр дүнг бүртгэж, тухай бүр аудитаар шалгуулагчдаас нотлох баримт гаргуулан авна.
- 6.5. Дотоод хяналтын шалгалтын үеэр эсвэл хяналтын шалгалт дууссаны дараа Аудитор нь илэрсэн гол үр дүнгүүдийг аудитаар шалгуулагчид танилцуулж дотоод хяналтын шалгалтыг дуусгана.
- 6.6. Аудитаар шалгуулагч нь ямар нэгэн хүсэлт/санал гаргасан тохиолдолд Аудитор нь хяналтын хурлын үеэр тухайн саналыг хэлэлцэж, шийдвэрлэнэ.
- 6.7. Хяналтын багийн ахлагч болон Аудитор нь хаалтын хурлыг төлөвлөгөөний дагуу хийж, аудитаар илэрсэн үр дүнг тэдгээрийн ангиллын хамт Гүйцэтгэх удирдлагад танилцуулна.
- 6.8. Аудитор нь аудитаар шалгуулагчийн зөвшөөрөлгүйгээр ямар нэгэн нотлох баримт болон бүртгэлийн хувийг авах, зураг хэлбэрээр авах зэргийг хориглоно.

- 6.9. Аудитаар шалгуулагчийн урьдчилсан зөвшөөрөлгүйгээр эсвэл дотоод хяналтын шалгалтын хамрах хүрээнд ороогүй тохиолдолд Аудитор нь нотлох баримт, бүртгэл, баримт бичгийг дотоод хяналтын шалгалт хийж буй газраас авч гарах, ажлын бус цагаар ашиглахыг хориглоно.
- 6.10. Аудитор нь илэрсэн үр дүнг дараах байдлаар ангилан танилцуулна. Үүнд:
- 6.10.1. **Үл тохирол – (ҮТ)** – Шалгуурыг хангаагүй эсвэл шалгуураас зөрсөн тохиолдол. Бүх үл тохирлыг нотлох баримтаар баталгаажуулсан байна.
- 6.10.2. **Сайжруулах боломж – (СБ)** – Шалгуурт нийцээгүй эсвэл маш бага хазайлт. Сайжруулах боломжуудыг нотлох баримттайгаар эсвэл баримтгүйгээр үзүүлж болно.
- 6.10.3. **Нийцэл** – Шалгуур эсвэл шаардлагыг хангаж байгаа тохиолдол. Бүх тохирлыг нотлох баримтаар баталгаажуулна.
- 6.10.4. **Сайн туршлага** – ББСБ-ын үйл ажиллагааны гүйцэтгэлийг сайжруулахаар ББСБ-аас авч хэрэгжүүлж байгаа бүх процесс, туршлагыг Сайн туршлага гэж авч үзэж болно. Сайн туршлагыг нотлох баримтаар баталгаажуулах шаардлагагүй.
- 6.11. Аудитаар шалгуулагчид дотоод хяналтын шалгалтаар илэрсэн зөрчлийг ойлгуулан засах арга хэмжээ авхуулах үүднээс Аудитор нь илрүүлсэн үр дүнгээ харгалзах шаардлагын/стандартын заалт/дэд заалт/хяналттай холбон тайлагнана.
- 6.12. Аудитор нь хяналтын тайланг аудит хийгдэж дууссанаас хойш ажлын 7 хоногт багтаан зохих форматын дагуу тайлагнана. Тайланг ББСБ-д хүргүүлнэ.
- 6.13. Нэгдсэн тайланг Гүйцэтгэх удирдлагад мэдээлэл өгөх зорилгоор хүргүүлж болно.

#### Долоо. Хяналтын шалгалтын дараах процесс

- 7.1. ББСБ нь хяналтын тайланг хүлээн авсны дараа дотоод хяналтын шалгалтын хүрээнд өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг боловсруулна.
- 7.2. Дотоод хяналтын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг холбогдох журмын дагуу боловсруулан батлуулна.
- 7.3. Бүх Үл тохирол болон Сайжруулах үр дүнгийн хувьд засах арга хэмжээг төлөвлөнө.
- 7.4. Үл тохирлуудын хувьд дахин гарахаас сэргийлэх зорилгоор шалтгааныг тодорхойлж, сайжруулах арга хэмжээг төлөвлөнө.
- 7.5. Дотоод хяналтын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөөнд үүрэг хариуцлага болон хэрэгжүүлэх хугацааг тусгана.
- 7.6. Хяналтын тайлангийн үр дүн, тэдгээрийг хаасан байдал, баталгаажуулалтын үр дүнг Дотоод хяналтыг хэрэгжүүлэх этгээд нь Гүйцэтгэх удирдлагад хурлаар танилцуулна.
- 7.7. Дотоод хяналтын бүртгэл, үр дүн, тэдгээрийн хаалт болон баталгаажуулалтыг хадгална.

#### Найм. Дотоод хяналтын үйл ажиллагаанд хориглох зүйлс

- 8.1. Дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх этгээдэд дараах зүйлсийг хориглоно. Үүнд:
- 8.1.1. Нууцын зэрэглэлтэй баримт бичиг, түүнтэй холбогдох мэдээллийг бусдад тараах;
- 8.1.2. Хувийн ашиг сонирхлын үүднээс хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулах;
- 8.1.3. Шалгалтын үр дүнг санаатайгаар худал мэдээлэх, авлигал авах, авахаар санаархах;
- 8.1.4. Аливаа иргэн, хуулийн этгээдийг байгууллагын өмнө төлөөлөх;
- 8.1.5. Хууль тогтоомж, энэхүү журамд хориглосон бусад;

#### Ес. Бусад

- 9.1. Дотоод аудитаар илэрсэн зөрчил, дутагдлын дагуу буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомж, болон байгууллагын дотоод журам заасан хариуцлага ногдуулна.
- 9.2. Дотоод аудитаар илэрсэн зөрчил дутагдал нь гэмт хэргийн шинжтэй бол асуудлыг хуулийн байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.
- 9.3. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд эрүүгийн, захиргааны, зөрчлийн хариуцлага хүлээлгэхээргүй бол түүнд Компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”-д заасны дагуу хөдөлмөрийн сахилгын арга хэмжээ ногдуулна.
- 9.4. Журмыг зөрчсөн ажилтны үйлдэл нь Компанийн нэр хүнд, хөрөнгө, үйл ажиллагаанд хохирол учруулсан бол түүнд сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр хохирлыг хариуцуулна.

--ooOoo--